

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Галшар сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2022/46/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Чингис хот
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Б.Хуланхатан
Утас: 99008827

Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.8 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.9 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.1. Залруулсан алдаа	13
4.2. Төлбөрийн акт	13
4.3. Албан шаардлага	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
6. Аудитын тайлангийн хавсралт	16
6.1. Төлбөрийн акт №14 /А2370452/ ХЭА-2022/46/НА-СТА-ТШЗ	16
6.2. Албан шаардлага № 114 /А2370452/ ХЭА-2022/46/НА-СТА-ТШЗ	17
6.3. Албан шаардлага №115 /А2370452/ ХЭА-2022/46/НА-СТА-ТШЗ	18
6.4. Албан шаардлага № 116 /А2370452/ ХЭА-2022/46/НА-СТА-ТШЗ	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

додд. 03.09 № 178
танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ГАЛШАР СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Г.ЦЭВЭЛСҮРЭН ТАНАА

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Галшар сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Галшар сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайланг хугацаа: 2021. 12.31

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	84,443,205.7	104,688,295.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	2,800.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	2,800.00
3121	Төгрөг	-	2,800.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах		2,800.00
35	БАРАА МАТЕРИАЛ	75,443,205.77	98,435,495.77
354	Хангамжийн материал	17,493,205.77	36,635,495.77
35410	Бичиг хэргийн материал	1,904,175.00	2,416,975.00
35420	Аж ахуйн материал	12,377,680.77	28,930,520.77
35440	Түлш, шатах тослох материал	1,289,350.00	3,366,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,922,000.00	1,922,000.00
35600	Мал амьтад	57,950,000.00	61,800,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	9,000,000.00	6,250,000.00
36300	Тэжээлийн нөөц	9,000,000.00	6,250,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,891,249,526.87	3,457,294,405.44
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,891,249,526.87	3,457,294,405.44
392	Биет хөрөнгө	2,860,998,026.95	3,410,335,905.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,522,928,178.00	2,772,669,596.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(225,534,305.82)	(269,782,541.13)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	128,184,800.00	248,194,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(52,735,366.65)	(26,066,226.63)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	275,344,441.25	365,503,617.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(116,359,756.95)	(137,189,884.12)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	303,107,633.17	350,703,763.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	(177,304,589.09)	(193,122,793.94)
39214	Бусад үндсэн хөрөнгө	354,075,036.20	462,397,207.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	(150,708,043.16)	(162,971,633.06)
393	Биет бус хөрөнгө	30,251,499.92	46,958,499.89
39301	Програм хангамж	680,000.00	680,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(470,500.08)	(521,500.11)
39303	Бусад биет бус хөрөнгө	30,042,000.00	46,800,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,975,692,732.64	3,561,982,701.21
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,975,692,732.64	3,561,982,701.21
51	Засгийн газрын хувь оролцоо	2,975,692,732.64	3,561,982,701.21
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	409,675,576.37	409,675,576.37
51101	Өмч: - төрийн	409,675,576.37	409,675,576.37
512	Хуримтлагдсан үр дүн	2,523,443,617.32	3,109,733,585.89
51210	Өмнөх үеийн үр дүн	2,523,443,617.32	2,523,443,617.32
51220	Тайланг үеийн үр дүн	-	586,289,968.57
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	42,573,538.95	42,573,538.95
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,975,692,732.64	3,561,982,701.21

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	2,553,961,010.1	1,225,128,909.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,089,792,990.67	583,159,042.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,089,792,990.67	583,159,042.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,089,792,990.67	583,159,042.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	227,900.00	216,400.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,089,565,090.67	582,942,642.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	464,168,019.50	641,969,867.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	46,289,919.50	131,464,167.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,029,000.00	6,316,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,403,766.00	4,606,698.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон	11,857,153.50	120,541,469.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	417,878,100.00	510,505,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	417,878,100.00	510,505,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	585,558,154.64	638,838,940.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	582,569,688.64	637,625,940.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	544,400,348.18	596,308,901.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	249,611,395.00	261,344,839.00
210101	Үндсэн цалин	174,220,751.00	174,850,801.00
210102	Нэмэгдэл	52,673,774.00	62,659,559.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,881,000.00	3,236,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	19,835,870.00	20,598,479.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,725,731.04	35,398,641.16
210201	Тэтгэврийн даатгал	20,541,498.08	25,337,413.06
210202	Тэтгэмжийн даатгал	3,627,256.36	2,822,359.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,275,341.88	2,061,544.90
210204	Ажилгүйдлийн даатгал	479,574.94	470,665.77
210205	Эрүүл мэндийн даатгал	4,802,059.78	4,706,657.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,903,781.00	38,010,893.00
210301	Гэрэл, сахилгаан	8,797,781.00	8,391,405.00
210302	Түлш, халаалт	16,106,000.00	29,563,188.00
210303	Цэвэр, бохир ус	-	56,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	40,619,126.93	38,681,310.00
210401	Бичиг хэрэг	4,912,940.00	6,492,000.00
210402	Тээвэр, шатахуун	16,934,437.00	24,621,560.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,986,600.00	2,376,400.00
210404	Ном, хэвлэл	263,000.00	198,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,058,200.00	569,850.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	4,423,000.00
210408	Бараа материал акталсны зардал	12,463,949.93	-
2105	Нормативт зардал	1,625,450.00	395,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,625,450.00	395,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,159,411.00	27,158,019.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	120,000.00	180,000.00
210604	Урсгал засвар	17,039,411.00	26,978,019.00
2107	Томилголт, зочны зардал	6,827,500.00	9,215,500.00
210702	Дотоод албан томилголт	6,827,500.00	9,215,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,480,588.00	29,910,276.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,176,996.00	24,324,906.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	575,625.00	500,650.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	194,664.00	165,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	86,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	4,200,000.00
210807	Газрын төлбөр	121,303.00	93,720.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	139,447,365.21	156,194,423.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,973,215.00	39,485,560.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	481,200.00	1,044,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	113,992,950.21	115,663,963.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,169,340.46	41,317,039.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,139,334.00	12,322,342.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	5,480,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,139,334.00	6,842,142.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	35,030,006.46	28,994,697.34
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,030,006.46	28,921,609.84
213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	-	73,087.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,988,466.00	1,213,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,988,466.00	1,213,000.00
223001	Бусад хөрөнгө	2,988,466.00	1,213,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,968,402,855.53	586,289,968.57
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	31,820,127.22	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	31,820,127.22	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(31,820,127.22)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,936,582,728.31	586,289,968.57

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайланг хугацаа: 2021.12.31 / төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	409,675,576.37	42,573,538.95	586,860,889.01		1,039,110,004.33
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	409,675,576.37	42,573,538.95	586,860,889.01		1,039,110,004.33
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайланг үеийн үр дүн	-	-	1,936,582,728.31		1,936,582,728.31
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	409,675,576.37	42,573,538.95	2,523,443,617.32		2,975,692,732.64
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	409,675,576.37	42,573,538.95	2,523,443,617.32		2,975,692,732.64
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	409,675,576.37	42,573,538.95	2,523,443,617.32		2,975,692,732.64
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайланг үеийн үр дүн	-	-	586,289,968.57		586,289,968.57
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	409,675,576.37	42,573,538.95	3,109,733,585.89		3,561,982,701.21

**Хэнтий аймгийн Галшар сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021.12.31		/Төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	464,395,919.50	642,186,267.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	227,900.00	216,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	227,900.00	216,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	227,900.00	216,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	227,900.00	216,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	464,168,019.50	641,969,867.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	46,289,919.50	131,464,167.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,029,000.00	6,316,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,403,766.00	4,606,698.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,857,153.50	120,541,469.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	417,878,100.00	510,505,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	417,878,100.00	510,505,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	461,407,453.50	534,180,767.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	461,407,453.50	534,180,767.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	423,238,113.04	493,109,028.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	249,611,395.00	260,024,839.00
210101	Үндсэн цалин	174,220,751.00	171,068,970.00
210102	Нэмэгдэл	52,673,774.00	63,681,337.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,881,000.00	3,236,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	19,835,870.00	22,038,532.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,725,731.04	35,398,641.16
210201	Тэтгэврийн даатгал	20,541,498.08	25,582,839.68
210202	Тэтгэмжийн даатгал	3,627,256.36	2,576,932.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,275,341.88	2,061,545.28
210204	Ажилгүйдлийн даатгал	479,574.94	470,665.77
210205	Эрүүл мэндийн даатгал	4,802,059.78	4,706,657.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,823,781.00	37,500,893.00
210301	Гэрэл, шахилгаан	8,797,781.00	8,391,405.00
210302	Түлш, халаалт	15,026,000.00	29,053,188.00
210303	Цэвэр, бохир ус	-	56,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,982,367.00	29,322,210.00
210401	Бичиг хэрэг	3,782,650.00	5,318,400.00
210402	Тээвэр, шатахуун	14,114,417.00	20,630,060.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,986,600.00	2,500,400.00
210404	Ном, хэвлэл	263,000.00	299,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	835,700.00	573,850.00
2105	Нормативт зардал	735,000.00	590,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	735,000.00	590,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,826,686.00	30,233,200.00
210601	Багаж, техник хэрэгсэл	6,744,990.00	6,094,300.00
210604	Урсгал засвар	14,081,696.00	24,138,900.00
2107	Томилолт, зочны зардал	6,827,500.00	9,215,500.00
210702	Дотоод албан томилолт	6,827,500.00	9,215,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,230,738.00	39,678,185.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,927,146.00	34,092,815.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	461,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	575,625.00	500,650.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	194,664.00	243,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	86,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	4,200,000.00
210807	Газрын төлбөр	121,303.00	93,720.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,474,915.00	51,145,560.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,743,715.00	49,905,660.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дэдлага хийх	731,200.00	1,239,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,169,340.46	41,071,739.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,139,334.00	12,077,042.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	5,480,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,139,334.00	6,596,842.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	35,030,006.46	28,994,697.34
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,030,006.46	28,921,609.84
213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	-	73,087.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2,988,466.00	109,202,700.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,988,466.00	109,202,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,988,466.00	109,202,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,988,466.00	109,202,700.00
223001	Бусад хөрөнгө	2,988,466.00	109,202,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(2,988,466.00)	(109,202,700.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		2,800.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021.12.31

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны / төгрөгөөр /	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	511,005,700.00	481,800,490.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	508,005,700.00	480,587,490.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	500,445,500.00	473,029,148.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	268,045,800.00	260,024,839.00
210101	Үндсэн цалин	177,502,100.00	171,068,970.00
210102	Нэмэгдэл	61,997,900.00	63,681,337.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,960,000.00	3,236,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	24,585,800.00	22,038,532.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,267,700.00	35,398,641.16
210201	Тэтгэврийн даатгал	25,545,300.00	25,582,839.68
210202	Тэтгэмжийн даатгал	2,680,700.00	2,576,932.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,144,500.00	2,061,545.28
210204	Ажилгүйдлийн даатгал	536,200.00	470,665.77
210205	Эрүүл мэндийн даатгал	5,361,000.00	4,706,657.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,488,500.00	37,500,893.00
210301	Гэрэл, цахилгаан	9,663,600.00	8,391,405.00
210302	Түлц, халаалт	44,624,900.00	29,053,188.00
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	56,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,699,700.00	20,699,210.00
210401	Бичиг хэрэг	2,528,000.00	3,064,400.00
210402	Тээвэр, шатахуун	14,357,500.00	14,321,060.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,944,000.00	2,440,400.00
210404	Ном, хэвлэл	271,000.00	299,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	599,200.00	573,850.00
2105	Нормативт зардал	590,000.00	590,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	590,000.00	590,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,764,100.00	40,763,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,000,000.00	12,000,000.00
210602	Тавилга	9,500,000.00	9,500,000.00
210604	Урсгал засвар	19,264,100.00	19,263,800.00
2107	Томилголт, зочны зардал	9,500,000.00	9,215,500.00
210702	Дотоод албан томилолт	9,500,000.00	9,215,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,396,700.00	22,184,705.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр	16,600,000.00	16,599,335.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	461,400.00	461,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	503,500.00	500,650.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	252,000.00	243,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	86,000.00	86,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,200,000.00	4,200,000.00
210807	Газрын төлбөр	293,800.00	93,720.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,693,000.00	46,651,560.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,886,500.00	45,851,660.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	806,500.00	799,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,560,200.00	7,558,342.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,560,200.00	7,558,342.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,480,200.00	5,480,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,080,000.00	2,078,142.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,000,000.00	1,213,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,000,000.00	1,213,000.00
223001	Бусад хөрөнгө	3,000,000.00	1,213,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	511,005,700.00	481,800,490.16
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	510,505,700.00	481,584,090.16
132001	Орон нутгийн төсвөөс	510,505,700.00	481,584,090.16
120004	ТӨСӨВТ БАЙГ УУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	500,000.00	216,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	216,400.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайланг хугацаа: 2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл	/ төгрөгөөр /
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		128,867,667.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ		58,867,667.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		56,609,580.00
2104	Хангамж, бараа материалын зардал		8,363,000.00
210401	Бичиг хэрэг		2,254,000.00
210402	Тээвэр, шатахуун		6,049,000.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр		60,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		26,259,100.00
210601	Багаж, техник хэрэгсэл		21,384,000.00
210604	Урсгал засвар		4,875,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		17,493,480.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		17,493,480.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		4,494,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		4,054,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		440,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,185,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		2,185,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		2,185,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		73,087.50
213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг		73,087.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		70,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр		70,000,000.00
223001	Бусад хөрөнгө		70,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		128,867,667.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		128,867,667.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		6,316,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,010,198.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		120,541,469.50
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Галшар сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Хуланхатан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Галшар сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 1/37 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хэнтий аймгийн Галшар сумын Засаг даргын тамгын газрын эрхэм зорилго нь “Аливаа улс төрийн нөлөөнд автахгүй, төвийг сахисан, хамгийн шилдэг бөгөөд цаг үеэ олсон зөвлөгөө, бүх талын дэмжлэгээр Засаг даргын хангах, Засаг даргын үр нөлөөтэй, үр ашигтай тасралтгүй хэвийн жигд ажиллагааг баталгаатай хангах замаар эх орон, ард түмэндээ үнэнч шударгаар үйлчлэхэд оршино.” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Хэнтий аймгийн Галшар сумын Засаг даргын тамгын газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хэнтий аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Галшар сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Галшар сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 585.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 5.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Галшар сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 586.3 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	0.0	0.0
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	75.4	98.4	23.0
Үндсэн хөрөнгө	2,891.2	3,457.3	566.0
Нөөцийн бараа	9.0	6.3	(2.8)
Нийт хөрөнгө	2,975.7	3,562.0	586.3
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо	2,975.7	3,562.0	586.3
Засгийн газрын оролцоо/Өмч - Төрийн/	409.7	409.7	-
Өмнөх үеийн үр дүн	2,523.4	2,523.4	-
Тайлант үеийн үр дүн	-	586.3	586.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	42.6	42.6	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,975.7	3,562.0	586.3

Бараа материалын данс худалдаж авсан 118.5 сая, хандиваар авсан 3.0 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 6.2 сая төгрөгийн материалаар нэмэгдэж, Эрүүл мэндийн төвд

шилжүүлсэн 13.7 сая, зарцуулсан 93.7 сая төгрөгийн хөрөнгөөр хасагдаж бараа материалын 98.4 сая, нөөцийн барааны 6.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө данс худалдаж авсан 108.0 сая, хандиваар 35.0 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 538.7 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, акталсан 30.3 сая, дуудлага худалдаагаар худалдсан тээврийн хэрэгслийн 18.8 сая төгрөгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,562.0 сая болж 586.3 сая төгрөгөөр буюу тайлант үеийн үр дүнгээр өссөн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1,328.9 сая төгрөгөөр буюу 52.0 хувиар буурсан нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 55.0 сая төгрөгөөр буюу 9.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бараа үйлчилгээний бусад зардал байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 454.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 57.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 511.0 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэх 511.0 сая төгрөгийн төсөв баталсныг орон нутгийн төсвөөс 510.5 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 0.5 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 510.5 сая, туслах үйл ажиллагааны орлого 0.2 сая, нийт 510.7 сая төгрөгийн орлогын бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд 481.8 сая төгрөгийг зарцуулж 28.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 6.3 сая, дээд шатны төсвийн захирагчаас 2.0 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 120.6 сая, нийт 128.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж 128.8 сая төгрөгийг зарцуулж үлдэгдэл 0.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 124.0 сая төгрөгийн 7, цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 79.2 сая төгрөгийн 4, зарлагын 150.0 сая төгрөгийн 8 гүйлгээ нийт 353.2 сая төгрөгийн 19 гүйлгээг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

3.8 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоогдсон 1.3 сая төгрөгийн 1 албан шаардлага, 424.3 сая төгрөгийн 3 зөвлөмж өгснөөс албан шаардлага, 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 421.8 сая төгрөгийн 1 зөвлөмжийг биелүүлээгүй байна.

3.9 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 371.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 369.1 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлсэн.

4.1. Залруулсан алдаа

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

4.2. Төлбөрийн акт

Аудитаар залруулагдаагүй 2.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлсний орлогоос 2.5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

4.3. Албан шаардлага

Аудитаар 15.9 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 1.4 сая төгрөгийн цалингийн зардал шилжүүлж эдийн ангилал зөрүүлэн гүйлгээ хийсэн.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Батлагдсан төсвийн тэвчиж болох зардлаас 5.0 сая төгрөгийн сэргээн засах аппарат, 9.5 сая төгрөгийн тавилга худалдаж авсан.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Галшар сумын ЗДТГ	3	18.4			1	2.5	2	15.9		
Дүн		3	18.4			1	2.5	2	15.9		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Галшар сумын ЗДТГ	1	353.2					1	353.2		
Дүн		1	353.2					1	353.2		
Нийт дүн		4	371.6			1	2.5	3	369.1		



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 14 / Д 2370452
ХЭА 2022/46/НА-СГА-ТШБ

Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Галшар сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлсний орлогоос 2,484.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн 40 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ” гэсэн заалтыг зөрчиж байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.2 -д “Төрийн болон орон нутгийн эд хөрөнгийг түрээслүүлсэн, ашиглуулсны төлбөр болон борлуулсны орлогыг дутуу төвлөрүүлсэн, эсхүл төвлөрүүлээгүй” гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Төсөвт төвлөрүүлээгүй 2,484.0 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь “Нэр заагдаагүй бусад орлого” 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Галшар сумын ЗДТГ-ын дарга Ш.Цэвэлсүрэн, нягтлан бодогч М.Мөнх-Од нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

Аудитор

Аудитын менежер



Б.Хуланхатан

Д.Оюунтуяа



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 114/А237452
ХЭА - 2022/46/11А - СА - ТЦБ

Чингис хот

Зөрчил арилгах гухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Галшар сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвийн тэвчиж болох зардлаас 5.0 сая төгрөгийн сэргээн засах аппарат, 9.5 сая төгрөгийн тавилга худалдаж авсан.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1 дугаар зүйлийн 1.4.-д "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсангас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэж заасныг баримталж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Галшар сумын ЗДТГ-ын дарга Ш.Цэвэлсүрэн, нягтлан бодогч М.Мөнх-Од нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Аудитор

Аудитын менежер



Б.Хуланхатан

Д.Оюунтуяа



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 115/А 2370452
ХТХА - 2022/46/НА СТА-ТЦЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагийн Галшар сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны сайтад мэдээлбэл зохих 353.1 сая төгрөгийн 19 гүйлгээг мэдээлээгүй, мэдээллийг хуулийн хугацаанд, үнэн зөв мэдээлж байх гэсэн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Галшар сумын ЗДТГ-ын дарга Ш.Цэвэлсүрэн, нягтлан бодогч М.Мөнх-Од нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Аудитор

Аудитын менежер



Б.Хуланхатан

Д.Оюунтуяа



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 116/A2370452
ХЭА - 2022/46/НА-СА-ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хэнтий аймгийн Галшар сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 1,402.3 мянган төгрөгийн цалингийн зардал шилжүүлж эдийн ангилал зөрүүлэн гүйлгээ хийсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалын хэвсралт "Зардлын эдийн засгийн ангилал, ашиглах заавар"-ыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан зардлын эдийн засгийн ангиллыг зөрүүлж гүйлгээ хийдэг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Галшар сумын ЗДТГ-ын дарга Ш.Цэвэлсүрэн, нягтлан бодогч М.Мөнх-Од нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Аудитор

Б.Хуланхатан

Аудитын менежер

Д.Оюунтуяа

2317144297

СЮА0046 9674082

Монгол Улс, Чингис хот, 3-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 98601199

023040484